ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/83/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж, 3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103, Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-б/168

танай ________ -ны № ________ -т

АЙРАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Н.ЛХАГВАДЭЛГЭР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөг суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан

0100 04

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/168

танай ________ -ны № ________ -т

АЙРАГ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ЛХАГВАДЭЛГЭР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөг суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан

төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 47.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 419.0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 332.0 сая төгрөгийн 21 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.8 сая төгрөгийн 6 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 5 харилцагчдаас 8.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт хангалтгүй байна. Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдэл олгох журам баталсан ч мөрдөөгүй, 2022 онд ур чадварын нэмэгдэл олгоогүй байна. Энэ нь бусдын өмнө хүлээх хариуцлага бодитоор илэрхийлэгдэхгүй, тайлагнагдахгүй байх үр дагавартай.

Мөн Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт "Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.", НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 "14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:, 14.4.6.бүх зардал; гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 12 зорилго, 36 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 90.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 88.8 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **84,570,073.90** | **143,723,581.77** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 47,851,430.87 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 47,851,430.87 |
| **3121** | **Төгрөг** | - | 47,851,430.87 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 47,851,430.87 |
| **33** | **АВЛАГА** | 1,010,648.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 853,648.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 157,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 157,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 83,559,425.90 | 95,872,150.90 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,454,117.29 | 14,776,917.29 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,357,967.29 | 14,597,967.29 |
| 35130 | Эм боох материал | 96,150.00 | 178,950.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 70,105,308.61 | 81,095,233.61 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 898,400.00 | 2,507,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,702,440.00 | 12,928,890.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 6,508,945.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 400,000.00 | 400,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,910,030.00 | 6,454,960.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 52,194,438.61 | 52,294,938.61 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **842,146,475.73** | **803,203,695.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 842,146,475.73 | 803,203,695.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 836,365,225.65 | 797,854,195.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 834,166,023.00 | 819,151,623.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (43,720,744.20) | (55,419,261.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 42,073,780.00 | 42,293,230.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (23,325,510.45) | (28,717,194.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,453,677.00 | 36,453,677.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,415,243.39) | (30,893,859.61) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,568,663.18 | 21,568,663.18 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,540,419.49) | (8,687,681.82) |
| 39217 | Ном | 2,105,000.00 | 2,105,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,781,250.08 | 5,349,500.16 |
| 39301 | Програм хангамж | 2,387,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,091,749.92) | (863,499.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,486,000.00 | 4,486,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **926,716,549.63** | **946,927,277.12** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **926,716,549.63** | **946,927,277.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 926,716,549.63 | 946,927,277.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 692,467,012.52 | 692,467,012.52 |
| 51101 | Өмч: - төрийн | 692,467,012.52 | 692,467,012.52 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 159,502,484.49 | 236,641,115.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 159,502,484.49 | 217,506,583.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 19,134,532.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 74,747,052.62 | 17,819,149.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **926,716,549.63** | **946,927,277.12** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **381,216,376.00** | **441,349,741.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,783,600.00** | **6,728,395.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,783,600.00 | 6,728,395.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө | | 219,450.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал | 2,783,600.00 | 6,508,945.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **378,432,776.00** | **434,621,346.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 333,129,700.00 | 369,677,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 27,454,500.00 | 369,677,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 305,675,200.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 157,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 103,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 157,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,146,076.00 | 64,840,646.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,146,076.00 | 64,840,646.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **380,081,822.78** | **409,804,048.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **380,081,822.78** | **409,804,048.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 369,798,698.78 | 409,132,048.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249,839,331.00 | 259,361,502.13 |
| 210101 | Үндсэн цалин | 180,058,896.00 | 212,708,895.13 |
| 210102 | Нэмэгдэл | 40,691,001.00 | 41,588,502.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,566,400.00 | - |
| 210104 | Урамшуулал | 19,523,034.00 | 5,064,105.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,145,253.00 | 32,422,579.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,196,153.00 | 22,101,461.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,487,200.00 | 2,583,101.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,989,900.00 | 2,066,481.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 497,400.00 | 505,325.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,974,600.00 | 5,166,208.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,846,076.00 | 48,791,498.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,815,218.00 | 5,149,272.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,659,700.00 | 36,921,905.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,371,158.00 | 6,720,321.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,885,059.00 | 3,257,810.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 842,280.00 | 411,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 665,250.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 224,186.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 117,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 389,950.00 | 139,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,646,393.00 | 2,706,770.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 8,145,395.00 | 29,729,095.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 37,600.00 | 52,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,087,795.00 | 29,655,795.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 20,000.00 | 20,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 891,500.00 | 93,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 240,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 651,500.00 | 93,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,127,500.00 | 495,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 839,500.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 495,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,722,584.78 | 34,981,564.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 7,484,988.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 591,529.00 | 745,506.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,131,055.78 | 26,751,070.29 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,283,124.00 | 672,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 672,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 672,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,083,124.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,083,124.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,134,553.22** | **31,545,692.58** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 12,411,160.09 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 12,411,160.09 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (12,411,160.09) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,134,553.22** | **19,134,532.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **381,744,076.00** | **435,854,541.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,179,695.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,179,695.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 103,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 103,500.00 |
| 120047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 1,076,195.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **381,744,076.00** | **434,674,846.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 333,129,700.00 | 369,677,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 27,454,500.00 | 369,677,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 305,675,200.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,468,300.00 | 157,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,468,300.00 | 157,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,146,076.00 | 64,840,646.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,146,076.00 | 64,840,646.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **344,247,976.00** | **388,003,110.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **344,247,976.00** | **388,003,110.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **333,964,852.00** | **387,331,110.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 236,605,473.00 | 258,507,854.13 |
| 210101 | Үндсэн цалин | 166,825,038.00 | 211,855,247.13 |
| 210102 | Нэмэгдэл | 40,691,001.00 | 41,588,502.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,566,400.00 | - |
| 210104 | Урамшуулал | 19,523,034.00 | 5,064,105.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,145,253.00 | 32,422,579.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,196,153.00 | 22,101,461.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,487,200.00 | 2,583,101.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,989,900.00 | 2,066,481.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 497,400.00 | 505,325.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,974,600.00 | 5,166,208.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,846,076.00 | 48,791,498.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,815,218.00 | 5,149,272.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,659,700.00 | 36,921,905.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,371,158.00 | 6,720,321.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,593,016.00 | 157,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 448,700.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 495,450.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 224,186.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 6,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,559,450.00 | 157,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,859,230.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 11,593,725.00 | 32,083,925.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 47,400.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 11,226,325.00 | 32,083,925.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 320,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 357,900.00 | 1,482,170.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 57,900.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 1,482,170.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,127,500.00 | 495,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 839,500.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 495,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 499,909.00 | 13,391,084.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 8,141,488.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 499,909.00 | 5,249,596.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,283,124.00** | **672,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 672,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 672,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,083,124.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,083,124.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **37,496,100.00** | **47,851,430.87** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,890,600.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,890,600.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,890,600.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 9,884,600.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 6,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(9,890,600.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 27,605,500.00 | 47,851,430.87 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 47,851,430.87 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 692,467,012.52 | 74,747,052.62 | 159,502,484.49 | 926,716,549.63 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **692,467,012.52** | **74,747,052.62** | **159,502,484.49** | 926,716,549.63 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **692,467,012.52** | **74,747,052.62** | **159,502,484.49** | 926,716,549.63 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **692,467,012.52** | **74,747,052.62** | **159,502,484.49** | 926,716,549.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 58,004,098.62 | 58,004,098.62 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **692,467,012.52** | **74,747,052.62** | **217,506,583.11** | 984,720,648.25 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (56,927,903.62) | - | (56,927,903.62) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 19,134,532.49 | 19,134,532.49 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **692,467,012.52** | **17,819,149.00** | **236,641,115.60** | 946,927,277.12 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 437,036,100.00 | 387,846,110.13 | 49,189,989.87 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 437,036,100.00 | 387,846,110.13 | 49,189,989.87 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,036,100.00 | 387,174,110.13 | 49,861,989.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 290,819,800.00 | 258,507,854.13 | 32,311,945.87 |
| 210101 | Үндсэн цалин | 244,954,400.00 | 211,855,247.13 | 33,099,152.87 |
| 210102 | Нэмэгдэл | 42,231,700.00 | 41,588,502.00 | 643,198.00 |
| 210104 | Урамшуулал | 3,633,700.00 | 5,064,105.00 | (1,430,405.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,480,100.00 | 32,422,579.00 | 4,057,521.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,885,200.00 | 22,101,461.58 | 2,783,738.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,898,700.00 | 2,583,101.64 | 315,598.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,319,000.00 | 2,066,481.04 | 252,518.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 579,700.00 | 505,325.84 | 74,374.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,797,500.00 | 5,166,208.90 | 631,291.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,291,700.00 | 48,791,498.00 | 2,500,202.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000.00 | 5,149,272.00 | 1,850,728.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,921,700.00 | 36,921,905.00 | (205.00) |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,370,000.00 | 6,720,321.00 | 649,679.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,160,000.00 | 32,083,925.00 | 10,076,075.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,160,000.00 | 32,083,925.00 | 10,076,075.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,500,000.00 | 1,482,170.00 | 17,830.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,482,170.00 | 17,830.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 814,000.00 | 495,000.00 | 319,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 814,000.00 | 495,000.00 | 319,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,970,500.00 | 13,391,084.00 | 579,416.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,720,500.00 | 8,141,488.00 | 579,012.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,250,000.00 | 5,249,596.00 | 404.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 672,000.00 | (672,000.00) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 672,000.00 | (672,000.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 672,000.00 | (672,000.00) |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 437,036,100.00 | 435,697,541.00 | 1,338,559.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 369,677,200.00 | 369,677,200.00 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 369,677,200.00 | 369,677,200.00 | - |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 67,358,900.00 | 64,944,146.00 | 2,414,754.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 67,358,900.00 | 64,840,646.00 | 2,518,254.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас | | 103,500.00 | (103,500.00) |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 1,076,195.00 | (1,076,195.00) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгө | | 1,076,195.00 | (1,076,195.00) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **47,851,430.87** | (47,851,430.87) |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | 1.00 | (1.00) |
| 610001 | Төсвийн байгууллага | - | 1.00 | (1.00) |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | - | 21.00 | (21.00) |
| 620001 | Удирдах ажилтан | - | 1.00 | (1.00) |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | 13.00 | (13.00) |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | 7.00 | (7.00) |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **157,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **157,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 157,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 157,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 157,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 157,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 157,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 157,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49.5 сая төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 49.5 сая төгрөгийн 2 алдааг залруулллаа. Үүнд:

**Залруулсан алдаа:**

1. Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 49.3 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан.
2. Хасагдсан хөрөнгийн 0.2 сая төгрөгийн элэгдэл хасагдаагүйг залруулсан.

Аудитаар нийт 4 зөрчил[2] илэрснээс, 4 зөвлөмж өгсөн.

### 3.3 Зөвлөмж

### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 418.97 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 332.0 сая төгрөгийн 21 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.8 сая төгрөгийн 6 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

**2. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Анхан шатны баримтын тулгалтаар 5 харилцагчдаас 8.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

**3. Тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт хангалтгүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодогч жилийн тайланг гаргахын өмнө тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг тооцон, хянан, баталгаажуулалтыг хангаж хариуцлагатай ажиллах.

**4. Дотоод хяналттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдэл олгох журам баталсан ч мөрдөөгүй, 2022 онд ур чадварын нэмэгдэл олгоогүй байна. Энэ нь бусдын өмнө хүлээх хариуцлага бодитоор илэрхийлэгдэхгүй, тайлагнагдахгүй байх үр дагавартай.

Мөн Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт "Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.", НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 "14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:, 14.4.6.бүх зардал; гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгох тухай Засгийн газрын 382-р тогтоолыг мөрдөж ажиллах, үнэн зөв байх, цаг хугацаандаа байх зарчмуудыг мөрдөж гарсан ажил гүйлгээг тухай бүрт нь бодитой бүртгэх

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 49.3 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан. | 1 | 49,251.1 | | | 1 | 49,251.1 | 1 | 49,251.1 | | | | |
| Хасагдсан хөрөнгийн 0.2 сая төгрөгийн элэгдэл хасагдаагүйг залруулсан. | 1 | 236.1 | | | 1 | 236.1 | 1 | 236.1 | | | | |
| **Дүн** | **2** | **49,487.2** | **-** | **-** | **2** | **49,487.2** | **2** | **49,487.2** | **-** | **-** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтын тулгалтаар 5 харилцагчдаас 8.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. | 1 | 8,259.5 | | | | | 1 | 8,259.5 | | | | |
| Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт хангалтгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг баталсан ч мөрдөөгүй, 2022 онд ур чадварын нэмэгдэл олгоогүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 3 | 8,259.5 | | | | | 3 | 8,259.5 | | | | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 418.97 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 332.0 сая төгрөгийн 21 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.8 сая төгрөгийн 6 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | - | - | | - | 1 | - |
| **Дүн** | **1** | | **-** | **-** | | **-** | **1** | **-** |